

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны дугаар
сарын -ны өдөр

Улаанбаатар
хот

**ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН БИРЖИЙН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуульд доор дурьдсан агуулгатай дараахь хэсэг нэмсүгэй:

1/ 4 дүгээр зүйлийн 7, 8, 14-16 дахь хэсэг:

“4.7. Бирж нь энэ хуулийн 4.5-д заасан жагсаалтад орсон бараа, түүхий эдийг экспортод гаргах тохиолдолд биржээр арилжсан тухай тодорхойлолтыг Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хуульд заасан экспортын барааны гарал үүслийг гэрчлэх эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.”

4.8. Энэ хуулийн 4.7-д заасан биржээр арилжсан тодорхойлолт болон Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хуульд заасан экспортын барааны гарал үүслийг гэрчлэх баримт бичигт үндэслэн Гаалийн байгууллага энэ хуулийн 4.5-д заасан жагсаалтад орсон бараа, түүхий эдийг гаалийн хилээр нэвтрүүлнэ.

4.14. Бирж нь хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн чанарыг тодорхойлох, анхан шатны боловсруулалт хийх, биржийн баталгаат агуулахад хадгалах, биржийн итгэмжлэгдсэн тээвэрлэгчээр тээвэр хийх зориулалт бүхий ложистикийн төвтэй байна.

4.15. Бирж нь энэ хуулийн 4.14-т заасан чиг үүрэг бүхий аймаг, сумын хуулийн этгээд, байгууллагад биржийн ложистикийн төв итгэмжлэл олгож болно.

4.16. Ложистикийн төвийн үйл ажиллагааны журмыг Хөдөө аж ахуйн бирж батална.”

2/ 10 дугаар зүйлийн 9-12 дахь хэсэг:

“10.9. Биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн нэр нь түүний оноосон нэр болон “Хөдөө аж ахуйн брокер” гэсэн дэлгэрэнгүй тэмдэглэгээ, эсвэл “ХААБ” гэсэн товчилсон тэмдэглэгээ үгнээс бүрдэнэ.

10.10. Биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлгүй байгууллага “ХААБ” гэсэн нэр хэрэглэхийг хориглоно.

10.11. Биржийн арилжааны зуучлагч /брокер/ нь Биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн мэргэжлийн байгууллагад гишүүнчлэлтэй байна.

10.12. Биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн мэргэжлийн байгууллага нь биржийн арилжааны зуучлагч /брокер/-дыг эгнээндээ нэгтгэсэн, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах зорилго бүхий гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага байна.”

2 дугаар зүйл. Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн “зохион байгуулах” гэсний дараа “Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөл бүхий” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн дараахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 4 дүгээр зүйлийн 4.9 дэх хэсэг:

“4.9.Биржийн тусгай зөвшөөрөл, түүний үйл ажиллагаанд хяналт тавих журам болон биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн тусгай зөвшөөрөл, түүний үйл ажиллагаанд хяналт тавих журмыг Санхүүгийн зохицуулах хороо батална.

2/ 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг:

“10.3. Биржийн байнгын бус гишүүн оролцогч нь хоршоо байна.”

4 дүгээр зүйл. Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн 4.7 дахь хэсгийн дугаарыг “4.9” гэж, 4.7.1 дэх заалтын дугаарыг “4.9.1” гэж, 4.7.2 дахь хэсгийн дугаарыг “4.9.2” гэж, 4.8 дахь хэсгийн дугаарыг “4.10” гэж, 4.9 дэх хэсгийн дугаарыг “4.11” гэж, 4.10 дахь хэсгийн дугаарыг “4.12” гэж, 4.11 дэх хэсгийн дугаарыг “4.13” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 7.1.2 дахь заалт, 7.3 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл. Энэ хуулийг ... оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.